

## “Аймгийн Засаг даргын үйл ажиллагаа”

### хөндлөнгийн судалгааны тайлан

Мэдээлэл, сургалт, судалгааны “Зууны мэлмий” өв нь Орхон аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу аймгийн засаг даргын ажиллагаанд хөндлөнгийн судалгаа хийж дүгнэлт гаргав.

#### Нэг. Судалгааны зохион байгуулалт

“Зууны мэлмий” өвг нь уг судалгааг чанартай гүйцэтгэхэд анхаарч судалгааны үе шат, процесс бүрт хяналт тавьж мэдээллийн үнэ цэнэ, найдвартай байдлыг хангахүүднээс судалгааны багийг 25 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажилласан юм.

#### Судалгааны багийн гишүүд, үүрэг:

№	Багийн гишүүд	тоо	Гүйцэтгэсэн үүрэг
1	Багийн ахлагч	1	Судалгааны үх үе шатанд хяналт тавьж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, дүгнэх
2	Судлаач	2	Анхдагч мэдээллийг боловсруулалтад бэлтгэх, боловсруулах, дүгнэх, зөвлөмжийн төсөл бэлтгэх
3	Оператор	2	Мэдээллийг компьютерт шивэх, олшруулах
4	Хянагч	4	Мэдээлэл цуглуулагчийн үйл ажиллагааг хянах
5	Мэдээлэл цуглуулагч	16	Судалгааны үүврийн дагуу сум, багуудын иргэдээс мэдээлэл авах

Хөндлөнгийн судалгааг анкетийн аргаар багийн бүрэлдэхүүн судалгааны хөдөлбөрийн дагуу 2011 оны 02 сарын 23-ны өдрөөс эхлэн Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын 22 багийн 2000 иргэнийг хамруулан явуулав.

#### Судалгааны эх олонлог ба түүврийн хэмжээ

№	Багаар	Эх түүвэр /хүний тоо/	Түүврийн хэмжээ /хүний тоо/
<b>Баян-Өндөр сум</b>			
1	Зэст	4685	110
2	Оюут	5578	120
3	Уурхайчин	5692	140
4	Хүрэнбулаг	4639	110
5	Уртбулаг	3909	90
6	Согоот	4852	130
7	Дэнж	4929	110
8	Бүрэнбүст	3012	80

9	Шанд	6076	140
10	Наран	3616	80
11	Цагаанчулуут	4336	100
12	Булаг	3293	80
13	Баянцагаан	4522	100
14	Говил	3710	75
15	Рашаант	6673	140
16	Малчин	2308	50
17	Эрдэнэ	4453	80
18	Баянбулаг	2967	60
19	Их залуу	6533	140
<b>2Жаргалант сум</b>			
1	Улаантолгой	894	20
2	Жаргалант	1110	25
3	Дулаан-Уул	918	20
<b>Нийт дүн</b>			
№	20	88705	2000

Хоёр. Судалгааны паспортын хэсгийн ерөнхий мэдээлэл

Аймгийн засаг даргуйл ажиллагаанд өгөх хөндлөнгийн судалгааг судалгааны жтөлбөрийн дагуу тоон (тоон судалгаа анкетаар авч 2000 хүнийг хамруулсан) ба чанарын (чанарын судалгааг фокус бүлгийн ярилцлагаар авч салбар салбарын 5 үж хамрагдсан) хоёр аргыг хосолж явуулсан нь мэдээллийн судалгааны үндэслэлийг сайжруулсан юм.

Тоон судалгаанд хамрагдсан хүмүүсийг анкетад өгөгдсөн өгөгдөхүүнээр нь бүлэглэж үзэхэд аймгийн хүн амын болон ажил эрхлэлтийн байдлыг ерөнхийд нь хадгалсан тул судалгааны шаардлагыг хангасан гэж үзэх үндэстэй байна.

1. Оролцогчдын нас:
  - а/ 18-35 настай -35,1%
  - б/ 36-50 настай -44,6%
  - в/ 50- дээш настай -20,2%
2. Оршин суугаа газар:
  - а/ Гэр хороололд - 49,5%
  - б/ Орон сууцанд - 47,0%
  - в/ Хөдөө амьдардаг - 3,5%
3. Ам бүлийн хүний тоо:
  - а/ Ганц бие - 6,6%
  - б/ 2-3 - 36-2%

	в/ 4-6	- 48,0%
	г/ 7-оос дээш	-9,1%
4. Оролцогчдын боловсрол:	а/ дээд	- 34,3%
	б/ тусгай дунд	- 24,1%
	в/ бүрэн дунд	-39,5%
	г/ бага	- 2,0%
5. Хөдөлмөр эрхлэлт:	а/ улсын үйлдвэрт	- 20,8%
	б/ хувийн хэвшилд	- 37,8%
	в/ төсвийн байгууллагад	-15,5%
	г/ суралцдаг	-5,3%
	д/ тэтгэвэрт	- 10,2%
	е/ ажил эрхэлдэггүй	- 10,4%

#### Гурав. Судалгааны үр дүн

Тоон судалгаанд оролцогчид аймгийн засаг даргын 2010 оны ажиллагаанд 36,7% нь эерэг (8,6% нь маш сайн, 28,1% нь сайн) үнэлэлт өгсөн байхад 11,9% нь сөрөг (8,5% нь муу, 3,4% нь маш муу) үнэлэлт өгсөн байна. Харин сайн ч биш, муу ч биш гэж 37,7% нь дүгнэсэн.

Энэ байдлаас үзэхэд аймгийн засаг даргын үйл ажиллагаанд эерэг үнэлэлт нь сөрөг үнэлгээнээс 3 дахин орчим их байна. Энэ нь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа нийгэм – эдийн засгийн арга хэмжээ иргэдийн санал бодолд нийцэх тал давамгайлж буйг илэрхийлж байгааг харуулах баримт юм.

“Таны бодлоор аймгийн засаг дарга, тамгын газраас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмж хэрхэн өөрчлөгдөж байгаа вэ?” гэсэн асуултыг 3 позици бүхий хаалттай асуултаар асуухад

- Хэвэндээ байгаа 53,7%

- Сайжирч байгаа 31,6%

- Дордож байгаа 14,7% гэсэн дарааллаар хариулсгийн нь т үйлчилгээний чанар хүртээмжид эрс өөрчлөлт гарахгүй байгааг илтгэсэн үнэлэмж юм. Харин судалгаанд оролцогчдын бараг 1/3 нь (31,6%) сайжирч байгаа гэж үнэлсэн нь 2009 оны үеийнхээс 8,8% -иар өссөн байна. (2009 онд 22,8% нь сайжирч байгаа гэж үнэлж байсан)

Иргэд аймгийн хэмжээнд 2010 онд хэрэгжсэн дүнтэй, иргэдийн санал бодол, эрэлт хэрэгцээнд нийцсэн 20 шахам ажлыг нэрлэсэн юм. Эдгээрээс хамгийн их давтамжтайгаас нь дараалуулан эхний 9 ажлыг харуулбал:

1. Эрдэнэт хотын ногоон байгууламж
2. Хотын төвийн асфальтан зам, замын засвар
3. Гудамж талбай, замын гэрэлтүүлэг
4. Нийгмийн халамжийн үйлчилгээ
5. Цэнгэлдэх хүрээлэнгийн байгууламж
6. Хүүхдийн паркийн тохижилт
7. Худаг, цахилгааны хангамж
8. Цэцэрлэг сургууль шинээр барьсан
9. Ахмад настанд хандсан үйлчилгээ гэж нэрлэсэн байна.

Эндээс үзвэл аймгийн засаг даргын хот байгуулалт, хот тохижилтын хүрээнд хийсэн ажил иргэдэд илүү мэдрэгдсэн байна. Энэ нь хот байгуулалтын ажил хэн хүний нүдэнд илүү тусдагтай ч бас холбоотой байх магадлалтай юм. Дашрамд тэмдэглэхэд судалгаанд оролцогчдын 47% нь ямар нэгэн ажил нэрлүүг (голдуу мэдэхгүй гэж хариулсан) нь төрийн үйлчилгээ мэдээллийн хомсдлоос бүрэн ангижраагүйг харуулна.

Орхон аймгийн засаг даргуйл ажиллагааны хөтөлбөр нь Үндсэн чиглэлтэй бөгөөд эдгээрийн хэрэгжилтийн талаар иргэдээс хангалттай, дунд зэрэг, хангалтгүй, мэдэхгүй гэсэн 4 хувилбар бүхий хариултаас сонголт хийлгэж саналыг нь авсан юм. Засаг даргуйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг хангалттай хангалтгүй гэсэн 2 үндсэн хариултаар нь сийрүүлэн үзүүлье:

#### **А. Хангалттай.**

1. Нийгмийн халамж хамгааллын үйл ажиллагаа – 33,8%
2. Боловсрол, соёл, хүүхэд залуучуудын талаарх үйл ажиллагаа – 25,7%
3. Эрүүл мэнд, биеийн тамир спортын үйл ажиллагаа – 25,5%
4. Тээвэр холбоо харилцааг зохицуулах үйл ажиллагаа – 23,8%
5. Хот байгуулалт, хот тохижилтын бодлого үйл ажиллагаа – 19,6%
6. Мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх үйл ажиллагаа – 17,9%

7. Үйлдвэржилт, ЖДҮ-г хөгжүүлэх үйл ажиллагаа – 17,6%
8. Хууль эрх зүйн бодлого, зохицуулалт – 15,4%
9. Байгаль орчин, газрын харилцааны үйл ажиллагаа – 15,2%

**Б.Хангалтгүй.**

1. Хууль эрх зүйн бодлого зохицуулалтын үйл ажиллагаа – 35,6%
2. Хот байгуулалт, хот тохижилтын бодлого үйл ажиллагаа – 33,0%
3. Байгаль орчин, газрын харилцааны үйл ажиллагаа – 31,5%
4. Үйлдвэржилт, ЖДҮ-г хөгжүүлэх үйл ажиллагаа – 29,1%
5. Тээвэр, холбоо харилцааг зохицуулах үйл ажиллагаа – 28,2%
6. Эрүүл мэнд, биеийн тамир спортын талаарх үйл ажиллагаа – 24,8%
7. Боловсрол, соёл, хүүхэд залуучуудын талаарх үйл ажиллагаа – 22,4%
8. Мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх үйл ажиллагаа – 21,8%
9. Нийгмийн халамж, хамгааллын үйл ажиллагаа – 18,5%

Судалгаанд оролцогчдын хариулт үндсэн чиглэлүүдийн үнэлгээний ерөнхий хандлагыг илэрхийлж байгааг тэмдэглэх нь зүйтэй. “Хангалттай” үнэлгээнд эрүүл мэнд, биеийн тамир спортын үйл ажиллагаа эхний гуравт жагссан нь ажиглалтаас үзэхэд биеийн тамир спортын салбарын өндөр амжилтаас хамаарч байгаа юм. Үүнтэй нэгэн адил тээвэр холбооны салбарын үйл ажиллагаа холбоо харилцааны амжилтаас хамаарч эхний 4-р байрт орсон байх магадлалтай.

Аймгийн хэмжээнд архидалт, нийгмийн хэв журмыг гэмт хэрэг үлэмж өсч байгаа нь иргэдээс хууль эрх зорлого зохицуулалтын үйл ажиллагаанд “хангалтгүй” дүн тавьхад нөлөөлсөн байх талтай юм. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээс иргэдэд хамгийн ойлгомж муутай үндсэн чиглэлд мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх үйл ажиллагаа 26,1%, байгаль орчин, газрын харилцааны үйл ажиллагаа 19,5%, хууль эрх зүйн бодлого зохицуулалт 19,0% тус тус (мэдэхгүй гэж хариулсан) орж байгааг дашрамд дурдаж байна.

Судалгаанд хамрагдагсад аймгийн засаг даргын үзгээс эн түрүүнд шийдвэл зохих иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн ТОП-9 асуудлыг нэгтгэн үзүүлбэл:

1. Иргэдийг ажлын байраар хангах замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах
2. Хог хаягдлын менежментийг сайжруулж, хог хаягдлыг цэгцлэх

3. ЖДҮ-ийг дэмжиж иргэдийн хамрагдах боломжийг нэмэгдүүлэх
4. Эмнэлгийн үйлчилгээг сайжруулах
5. Нийгмийн хэв журмыг сайжруулж, архидалтын эсрэг тэмцэх
6. Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж зөв удирдах
7. Агаарын бохирдлын эсрэг тууштай арга хэмжээ авах
8. Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй болгох, шударга ёсыг тогтоох
9. Иргэдэд газар олгох ажилд ахиц гаргах

Тоон судалгаанд оролцогсдын ерөнхий үнэлэлмж, санал бодлыг хураангуйлахад

Чанарын судалгааг фокус бүлгийн ярилцлагын аргаар Орхон аймагт 10-аас дээш жил ажиллаж буй үнийг оролцуулан хийсэн. (барилгын үйлдвэрлэлийн салбараас -1, эрүүл мэндийн салбараас -1, төрийн бус байгууллагаас -1, хэвлэл мэдээллийн салбараас -1, банк санхүүгийн салбараас-1 тус тус төлөөлөл оролцсон)

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид аймгийн засаг даргын үйл ажиллагаанд “хангалттай” гэсэн өрхий дүгнэлт өгсөний хамт 2010 онд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зам талбай тохижуулах, гэр хорооллын болон замын гэрэлтүүлгийг сайжруулах, өрхийн амжиргааг дээшлүүлэх, талаар илүү идэвхи чармаалт гаргаж байгааг тэмдэглэсэн юм. Үүний зэрэгцээ аймгийн засаг даргын зүгээс дор дурдсан асуудалд анхаарлаа хандуулж ажиллах нь зүйтэй гэж ярилцлагад оролцогчид үзсэн.

Нэгдүгээрт Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд онцгой анхаарах Аймгийн засаг дарга өсөв, хөрөнгийн зарцуулалтад төрийн сангийн зүгээс тавьж байгаа хяналтыг сайжруулахад онцгой анхаарч энэ чиглэлээр өөрчлөлт хийх хэрэгтэй.

Хоёрдугаарт Орхон аймгийн барилгын компаниуд доройтож байгааг засаг дарга анхааралдаа авч барилгын үйлдвэрлэлийг сэргээх бодлого үйл ажиллагаа явуулах. Энэ үйл асуудлаар хөгжлийн бодлогын хэлтэс, хотын захирагчийн албанд өндөр шаардлага тавьж ажиллах нь зүйтэй.

Гуравдугаарт Аймгийн тулгамдсан асуудлуудыг эрэмбэлж хөрөнгө оруулалт хийх. Аймгийн өмнөх шийдвэрлэвэл зохих асуудлуудыг эрэмбэлэх нь хаа хаанаа ойлгомжтой болж хөрөнгийн үр өгөөж дээшлэх, хяналт тавих боломж нэмэгдэх ач холбогдолтой юм.

Дөрөвдүгээрт Хот тохижилтын ажлын чанар хангайг жишээ нь 4 -р хорооллын асфальтан зам, хорооллуудын замын өргөтгөл, ногоон байгууламжийн ажил чанаргүй болсноос дахин дахин хөрөнгө хүч гаргах шаардлагыг бий болгодог.

Хот тохижилт, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байгааг засаг дарга санаачлага гаргаж сайжруулах нь зүйтэй.

Тавдугаарт Аймгийн засаг даргын харьяа агентлаг, газар байгууллагуудад танил тал харах, хүнд суртал гаргах явдал хавтгайрсаныг засаг дарга анхааралдаа авч зарим албан тушаалтныг огцруулах, өөрчлөх, чөлөөлөх, сэлгэж ажиллуулах замаар шинэ уур амьсгал оруулах хэрэгтэй.

Зургаадугаарт Аймгийн хэмжээнд хэвлэл мэдээллийн эрхлөөг жинхэнэ ёсоор хөгжүүлэхэд орон нутгийн удирдлага шударга ёсны үүднээс хандаж ажиллах. Өөрөөр хэлбэл аймгийн засаг дарга, ИТХ аль нэгэн телевиз радиод давуу эрх олгох нь зохимжгүй юм.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид аймгийн засаг даргын үйл ажиллагаанд хангалттай хүн тавьж цаашид анхаарах асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлсэнийг дээр товчлон дүгнэлээ. Харин аймгийн засаг дарга харьяа агентлаг, байгууллага, газруудынхаа ажлын чанар байдал, ажилтнуудын үйлдвэр дүгнэлт хийж хариуцлага тооцож ажиллах шаардлагатайг онцгой анхааруулж байсныг тэмдэглэж байна.

#### Дөрөв. Зөвлөмж

2011 оныг аймгийн хэмжээнд өрхийн амжиргааг дээшлүүлэх жил болгосон нь иргэдийн нийтлэг эрх ашиг, сонирхолд бүрнээ нийцэж байгаа нь судалгааны явцад тодорхой харагдсан учир холбогдох хэлтэс газар агентлагуудад засаг даргын үүгээс онцгой үүрэг даалгавар өгч үр дүнг нь тооцож ажиллах нь зүйтэй юм.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2011 он шийдвэрлэх үүрэгтэй жил байх тул анализ, хэмжилт шинжилгээ хийж хөтөлбөрийн нөөцийг оновчтой ашиглаж хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг хангах

Иргэдийн болон фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын санал бодолд дүгнэлт хийж зарим хэлтэс, агентлаг газруудын удирдлага мэрэгжилтүүдийн хариуцлагыг өндөржүүлэх

Тайлан бичсэн:

Судалгааны багийн ахлагч, мэдээлэл, сургалт, судалгааны “Зууны мэлмий”

төвийн тэргүүн

Ш.ГАНБАТ